

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН
 ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2009 он

Баянхонгор

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт			
Хяналтад авсан нийт тоо		17	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			
Үүнээс	Биелсэн /100%/	5	
	Хэрэгжих шатандаа	12	
	Үүний дотор	90%	9
		70%	3
		50%	x
		30%	x
		10%	x
	Тасарсан	x	
Дүн:			
Хэрэгжилтийн дундаж хувь:		89.4%	

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
 ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР 2007-2015 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2010.03.29

Баянхонгор

№	Бодлогын заалт	Хэрэгжилт
1	Эдийн засгийн эрчимтэй, өндөр хурдацтай өсөлтийн үр дүнд ажлын байр олноор бий болж, хүн амын ядуурал 2 дахин буурах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 1999 хүнийг ажлын байранд зуучилснаас 1224 хүн байнгын зохистой ажлын байранд, 775 хүн түр ажлын байраар хангагдаж, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас 56,8 сая төгрөг зарцуулан 618 ажилгүй иргэнийг 13 мэргэжлээр сургаснаас 71,2 буюу 441 иргэн ажлын байртай болсон. /Хэрэгжилт-100%/
2	Хүний хөгжлийн индекс 0.83 болох;	2009 онд хүний хөгжлийн индекс 0,678 болж өмнөх оноос 0,002-оор нэмэгдсэн байна. /Хэрэгжилт-90%/
3	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2000 оныхоос гуравны хоёроор, эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулж, хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын халдварын тархалтыг тууштай бууруулах;	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2000 онд 52,6 промилль, 2009 онд 28,8 промилль болж, 23,8 пунктаар, эхийн эндэгдэл 2000 онд 100000 амьд төрөлтөд, 2009 онд 97,1 пунктээр буурсан. ХДХВ илрүүлэх шинжилгээнд 823 хүн хамрагдсанаас эерэг тохиолдол илрээгүй байна. /Хэрэгжилт-90%/
4	Бүх салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад мэдэгдэхүйц дэвшил гаргах;	Эрэгтэйчүүдийн төрийн бус байгууллага бий болж, эрэгтэйчүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг хариуцан гүйцэтгэж байна. Тухайлбал архи, тамхины хор хөнөөл, эрчүүдийн гэр бүл болон нийгэм дэхь үүрэг хариуцлагын талаар сургалтууд хийсэн. Банкнудаас хүйсээр ангилсан зээлийн мэдээг авах боломжгүй байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн даргын аймгийн Засаг даргатай байгуулж байгаа үр дүнгийн гэрээнд 470 өрхийг ядуурлаас гаргах бүтээгдэхүүнийг өгч, өрх гэр бүлүүдийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй болгох ажлыг хийсэн. 2006-2009 онд Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөртэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд 619 хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлж, 541 хүүхдийг хөдөлмөрөөс урьдчилсан сэргийлсэний 68.1 хувь эрэгтэй, 31.9 хувь эмэгтэй хүүхэд байна. Сургууль завсардалт 0.015 хувьтай байна. 2009 онд 1992 ажлын байр шинээр бий болгосны 68.9 хувь нь эмэгтэйчүүд ажил орсон байна. /Хэрэгжилт-70%/
5	Сургуулийн насны хүүхдийг бага боловсролд бүрэн хамруулж, хүйсийн ялгааг арилгах;	Аймгийн хэмжээнд бага боловсролын хамран сургалтын хувь 2008 онд 98 хувьтай байна. 2009-2010 оны хичээлийн жилд ЕБС-ийн 30 сургууль эрэгтэй 18144 хүүхэд суралцаж байгаагийн 8741 буюу 48.1 хувь нь хөвгүүд, 9403 буюу 51.9 нь эмэгтэй хүүхдүүд байна. /Хэрэгжилт-90%/
6	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж, сургалтын олон хувилбарт төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх үндэсний стандартын дагуу аймгийн ерөнхий боловсролын 29 сургууль тус бүр өөрсдийн төлөвлөгөөгөө боловсруулж байна.

	боловсруулж, хэрэгжүүлэх;	/Хэрэгжилт-90%/
7	Монгол улсын бүх сум байнгын цахилгаантай болж, бүх малчин өрх нар, салхины эрчим хүчээр хангагдах, дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахаас гадна цахилгаан эрчим хүч экспортолж эхлэх	Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан сумд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй, Хүрээмарал, Баянбулаг сумаас бусад сумд цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугаманд холбогдсон. Дээрх 2 сумдыг холбох хөрөнгийг 2010 оны төсөвт суулгасан. /Хэрэгжилт-100%/
8	Гэр бүл бэхжиж, хүн амын тоо өсөх, гэр бүлийн хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Нийгмийн ажилтануудыг гэр бүлд зөвлөгөө өгөх арга зүйгээр сургалт явуулж, чадавхжуулсан. Мөн үр дүнгийн гэрээнд жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх бүтээгдэхүүнийг суулган өгч хагас, бүтэн жилээр тайланг авч дүн шинжилгээ хийн ажиллаа. Сум бүр сумын шилдэг гэр бүлүүдээ тодруулан гэр бүлийн нэр хүндийг өгөх, олон нийтэд гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах арга хэмжээг авдаг болсон. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдтай байгуулсан гэрээнд гэр бүлд зөвлөгөө өгөх төв байгуулах бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэх зорилгоор төсөл хийж яаманд хүргүүлж 1.5 сая төгрөгийн санхүүжилт авч, төрийн бус байгууллагуудын удирдлагууд, гэр бүлд зөвлөгөө өгөх сайн дурын идэвхтэнүүдийг бэлтгэх сургалт зохион байгуулж, Баянхонгор суманд гэр бүлд зөвлөгөө өгөх ажлыг төрийн бус байгууллагууд, сайн дурын ажилтануудын оролцоотойгоор хийж эхэлсэн. Гэр бүлд зөвлөгөө өгөх ажлын хүрээнд сургууль завсардсан айлд ажил хийж байсан 3 хүүхдийг гэр нь буцааж, бичиг баримтгүй 3 хүүхдийг бичиг баримттай болгох, хүчирхийлэлд өртсөн 2 хүүхдийг хүчирхийллээс хамгаалах арга хэмжээг авсан. /Хэрэгжилт-90%/
9	Хамран сургалтын бохир жин бага боловсролд 99.1, дунд ангид 97.2, суурь боловсролд 98.3 хувьд тус тус хүрэх;	2009-2010 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 98.0 хувь, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 99 хувь, сургууль завсардалт 0.15 хувьтай байна. Хамран сургалт 99 хувьтай байна. /Хэрэгжилт-100%/
10	Олон улсын жишигт нийцсэн болон түүнд ойртсон, төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн тоог 10-аас дээш болгох;	Баянхонгор сумын төвд 4-р 10 жилийн сургуулийг ашиглалтад оруулснаар 3-р ээлж хичээллэхгүй болж ээлжийн коэффициент буурч, Одоо тус сургуульд 1616 сурагч, 70 гаран багш, 25 ажилчид ажиллаж байна. Хэрэгжилт-100%/
11	Олон улсын стандартад ойртсон хоёроос доошгүй их сургуультай болох;	2009 оны байдлаар Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн салбар сургууль, “Их Засаг Их сургуул”-ийн салбар “Хонгор” дээд сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж байна. Хонгор дээд сургуулийн дэргэд хөдөө аж ахуйн чиглэлээр “Өлзийт” мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг байгууллаа. /Хэрэгжилт- 90%/
12	Өрхийн эмнэлгийн тогтолцоо бүрэн төлөвших;	Өрхийн эмнэлгийн тогтолцоог сайжруулах талаар аймгийн хэмжээнд саналаа боловсруулж “Эрүүл мэндийн яам”-д хүргүүлсэн. /Хэрэгжилт-70%/

13	Сум, аймгийн эмнэлгүүдийн 60 хувь дүүргийн эмнэлгүүд 100 хувь эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр тоноглогдох;	Эрүүл мэндийн салбарын хөгжил-2 төслийн хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эмнэлгүүдийн 85 хувь нь эмчилгээ оношлогооны тоног төхөөрөмжөөр хангагдсан. /Хэрэгжилт-90%/
14	Өвчний түүхийг бүрэн цахим картад шилжүүлэх;	Өвчний түүхийг бүрэн цахим картад шилжүүлэх ажилд зориулж 50,0 сая төгрөг 2010 оны төсөвт суулгаж, ажлын эхлэл тавигдсан. /Хэрэгжилт-70%/
15	Хөдөөнөөс оношилгоо, эмчилгээнд зорчигчдын тоо 50-аас дээш хувь буурах;	2009 онд Улаанбаатар хот руу 1350 хүн явж эмчлүүлж зорчигчдын тоо өмнөх оноос 15 хувиар буурсан байна. /Хэрэгжилт- 100%/
16	Олон улсын стандартад нийцсэн эмчилгээ-оношилгооны төвийг байгуулан ажиллуулж, гадаад явж эмчилгээ, оношилгооны үйлчилгээ авдаг иргэдийн тоог мэдэгдэхүйц бууруулах;	Алсын зайн оношлогооны тоног төхөөрөмжийг нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт байрлуулан, клиникийн III эмнэлэгийн оношлогооны сүлжээнд холбож, оношлогооны анхны туршилтийг хийсэн. Хорт хавдар, дотрын өвчнүүд болон бэлгийн замын халдварт өвчнүүд эрт оношлогдож, цаг хугацаандаа хөнгөн шуурхай, чирэгдэлгүй эмчлэгдэх боломжтой болсон. /Хэрэгжилт-90%/
17	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар 75 хувьд хүрэх;	Аймгийн эрүүл мэндийн газрын үйлчилгээний хүртээмж, чанарын үзүүлэлт 2009 оны байдлаар 69,5 хувьтай болж өмнөх оноос 0,7 хувиар өссөн байна. /Хэрэгжилт-90%/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

БАЯНХОНГОР **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН**
ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ